



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 510

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 145,754,063.01 (нэг зуун дөчин таван сая долоон зуун тавин дөрвөн мянга жаран гурван төгрөг нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 5 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Эрдэнэс монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Хаянхярваад нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгүүлсэн хасуулсан тодорхойлолтын хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001615

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн
 57.0 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН
 ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ
				/төгрөг/		
1	Ниссан Навара пикап 7513 УНР хагас ачааны, арал:MNTCCUD40T001196 5	2011/2014	458100	32,599,446.31	0	2,500,000.00
2	Ниссан Навара пикап 7546 УНР хагас ачааны, арал:JN1CJUD22T0115255	2011/2014	701000	28,374,704.83	0	2,500,000.00
3	Ниссан Навара пикап 7549 УНР хагас ачааны, арал:JN1CJUD22T0115251	2011/2014	765580	28,374,704.83	0	2,500,000.00
4	Ниссан Навара пикап 7562 УНР хагас ачааны, арал:JN1CJUD22T0115252	2011/2014	619856	28,202,603.52	0	2,500,000.00
5	Ниссан Навара пикап 7563 УНР хагас ачааны, арал:JN1CJUD22T0115249	2011/2014	544629	28,202,603.52	0	2,500,000.00
НИЙТ ҮНЭ				145,754,063.01	-	12,500,000.00
				(нэг зуун дөчин таван сая долоон зуун тавин дөрвөн мянга жаран гурван төгрөг нэг мөнгө)		(арван хоёр сая таван зуун мянга)